

Статистикийн хэлтсийн 2 дугаар сарын 2 дахь 7 хоногт хийсэн

ажлын товч мэдээ

2018.02.08

Өлгий

1. Хүн ам, нийгэм, эрүүл мэнд, нийгмийн даатгал, гэмт хэргийн талаарх сүүлийн 5 жилийн тоон үзүүлэлтүүдээр Инфографик хийж портал сайтанд байршуулав.
2. 2018 оны 1-р сарын танилцуулгын Хүн ам, Татварын орлогын мэдээг нэгтгэж хүснэгт бэлтгэв.
3. Бугат сумын 2 багийн нэр, код нь Улсын бүртгэлийн иргэний мэдээллийн сангаас зөрүүтэй үзүүлэлтүүдийг арилгах арга хэмжээ авч эрхийн акт, бусад мэдээллийг хүргүүллээ.
4. Хэлтсийн портал сайтанд Үндэсний статистикийн хорооноос ирсэн зааврын дагуу нэгдсэн стандартад оруулж цэгцэлсэн.
5. Толбо сумын 1-р багийн Засаг даргын компьютерыг засаж ХАӨМС, Мал тооллогын программ суулгаж өгсөн.
6. Аж ахуйн нэгж, байгууллагын ААНБ-1 ба ААНБ-2 мэдээг БЗҮ-1, ХЗХ-1, ТББ-1 программд орсон жагсаалт хүрээний дагуу хуваарилах, тараах, эздийг олж маягт өгөх ажлуудыг хийж байна, Булган, Ногооннуур, Алтанцөгц сумуудын төрийн сангийн төлөөлөгч нарт маягт хүргүүлэх ажлыг зохион байгуулав.
7. Баян-Өлгий аймгийн төрийн байгууллага болон хувийн аж ахуйн нэгж, иргэдийг шаардлагатай тоон мэдээллээр хангаж ажиллав.
8. Хүнсний гол нэрийн барааны үнийн мэдээг 7 хоног бүрийн лхагва гарагт цуглуулж, төв руу дамжуулав.
9. Аж үйлдвэрийн сарын мэдээг 40 газраас цуглуулан авч хянан, шалгаж тооны болон логик алдаануудыг шалгаж хугацаандаа АҮ-1 програмд оруулсан.
10. Үндэсний статистикийн хорооноос зохион явуулсан онлайн хуралд Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны хураангуй болон дэлгэрэнгүй мэдээ“ (ААНБ 1, 2)-г цуглуулах, мэдээний нөхөлт, хамралт, чанарыг сайжруулах зорилгоор үндсэн мэдээлэл цуглуулж буй орон нутгийн статистикийн хэлтсийн ажилтнуудад мэдээлэл өгөх онлайн сургалтад оролцов.
12. Хэлтсийн 2017 онд хийсэн үйл ажиллагааны тайланг Баян-Өлгий аймгийн Засаг дарга болон Засаг даргын зөвлөлд тайлагнав.
13. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар болон Биеийн тамир, спортын газартай хамтран чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх, өвлийн спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор Толбо нуурт Цэвэр агаар-идэвхтэй хөдөлгөөн бүх нийтийн өдөрлөг зохион байгуулахад Статистикийн хэлтсийн хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ идэхтэй оролцов.
14. Баян-Өлгий аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар болон Эрүүл мэндийн газартай хамтран төлөвлөгөө, удирдамж баталж, сумдад улсын байцаагчийн эрхийн дагуу мэдээ, тайлангийн гаргалт, үнэн бодит байдлыг анхан шатны баримттай тулгаж шалгах, мэдээлэл цуглуулж буй ажлын явц, хамралт, мэдээллийг хэрхэн цуглуулж

байгаатай холбогдуулан нягтлан танилцах, хүн ам, өрхийн мэдээллийн сангийн өөрчлөлтийн тухай бүрийн хөтлөлт, шивэлтийн явцыг үзэж, зөрчлүүдийг цэгцэлж арилгасан байдлыг хянах, хагас жилийн малын түүвэр судалгаа болон Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгаанд хамрагдсан нэгжүүдэд мониторинг хийх, тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, туслах, дэмжлэг үзүүлэх зорилгоор дээрх 2 байгууллагын улсын байцаагч нартай хамтран ажиллахаар болов.

Статистикийн хэлтэс